



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
С.НАРАНЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.14 № 58

Мөнгөний нийлүүлэлт, банкны зээл болон
төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлого, мөнгөний нийлүүлэлт болон санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуулгыг тавьж байна.

1.2023-2026 онд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх болон бууруулах зорилгоор Монголбанкнаас нийт хэдий хэмжээний төгрөгийн эх үүсвэрийг зах зээлд нийлүүлж, хэдий хэмжээний эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн, тэдгээрийн цэвэр дүн хэдэн төгрөг байсан талаарх мэдээллийг арга хэмжээ тус бүрээр;

2.2024-2026 онд шинээр хэвлүүлсэн, эргэлтэд гаргасан цаасан дэвсгэртийн тоо хэмжээ, үүнээс хуучирсан болон гэмтсэн цаасан дэвсгэртийг нөхөн солиход, мөн мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд хэдий хэмжээний цаасан дэвсгэртийг зах зээлд нийлүүлсэн талаарх мэдээлэл;

3.Засгийн газраас хэрэгжүүлж байгаа орон сууцжуулах бодлого, “Орон сууцны санхүүжилтийн банк” байгуулах, “Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр”, газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, хадгалах агуулахын байгууламж байгуулах зэрэг их хэмжээний санхүүжилт шаардсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монголбанкны оролцооны хэлбэр, тухайлбал, Монголбанкнаас шууд болон шууд бусаар санхүүжилт, зээл, эх үүсвэр, баталгаа болон бусад хэлбэрээр хэдий хэмжээний дэмжлэг үзүүлж байгаа, уг санхүүжилтийн эх үүсвэр хаанаас бүрдэж байгаа, мөн эдгээр нь Монголбанкны баланс болон мөнгөний нийлүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгаа талаарх мэдээллийг төсөл, хөтөлбөр тус бүрээр.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.БАТБАЯР



2026000170